



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/518

Зуунмод

Зардал гаргах тухай

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.10, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дах хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үеийн сумдын онцгой комиссын бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний зардал болон зарим сумдад малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан сумдад олгох санхүүжилтийн дүнг хавсралтаар 175.000.000 (нэг зуун далан таван сая) төгрөгөөр баталсугай.

2. Зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (С.Магнайбаяр) нарт зөвшөөрсүгэй.

3. Хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулж, тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Сүүлийн ЗДТ-ын  
Ихэнх зэмсэг  
нэмгэрэх.

09/18